



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/06.

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Номын сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6 дахь хэсэг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн "Цахим номын санг ашиглах үйлчилгээний журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэмтэн нарийн бичгийн дарга /П.Амаржаргал/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



С.ЭНХЦЭЦЭГ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2020 оны 7 дугаар сарын 22-ний өдрийн 1/1 дугаар тушаалын хавсралт

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Цахим номын санг ашиглах үйлчилгээний журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Хууль зүйн үндэсний хүрээлэн (цаашид "ХЗҮХ" гэнэ) нөгөө талаас хэрэглэгчээр бүртгүүлж, хэрэглэгчийн нэр, нууц үг авсан этгээд (цаашид "хэрэглэгч" гэх) нар харилцан тохиролцож www.library.nli.mn цахим номын сангаар үйлчлүүлэх, цахим номын санд байршсан бүтээлийг татан авч ашиглахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 ХЗҮХ нь урьдчилсан мэдэгдэл, анхааруулгагүйгээр энэхүү үйлчилгээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх эрхтэй бөгөөд хэрэглэгч цахим номын санг үргэлжлүүлэн ашигласнаар тэдгээрийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Хоёр. Цахим номын сангийн үйл ажиллагаа

2.1. Цахим номын санг эрхлэн хөтлөхдөө хууль дээдлэх болон хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх зарчмыг баримтална.

2.2. ХЗҮХ-ийн "Хуульчдын номын сан" дахь цаасан болон хэвлэмэл материалыг нийтэд нээлттэй цахим хэлбэрээр хүргэнэ.

Гурав. Нэвтрэх эрхийн бүртгэл ба хамгаалалт

3.1. Хэрэглэгч www.library.nli.mn-д бүртгүүлэн нэвтэрснээр цахим номын сангийн үйлчилгээ авах эрхтэй болно.

3.2. Хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр, нууц үгийн нууцлалыг бүрэн хариуцах ба нэвтрэх нэр, нууц үгээ бусдад шилжүүлэх, хэрэглүүлэхгүй байх үүрэгтэй. Хэрэв хэрэглэгч өөрийн болон бусад хэрэглэгчийн цахим санд нэвтрэх эрхийг өөр гуравдагч этгээд ашигласан байж болзошгүй гэж үзвэл нууц үгээ солих арга хэмжээ авна.

3.3. Хэрэглэгчийн хувийн мэдээллийг (нэвтрэх нэр, нууц үг бусад хувийн мэдээлэл) хадгалах, дамжуулахдаа SSL сертификатын тусламжтай халдлагаас хамгаална.

3.4. Хэрэглэгчийн мэдээллийг хэрэглэгчийн хүсэлтэд хариулах, үйлчилгээнд шинэчлэл хийх, хэрэглэгчтэй холбоо барих, цахим санг ашиглах нөхцөлийн хэрэгжилттэй холбогдуулан ХЗҮХ ашиглах эрхтэй.

Дөрөв. Цахим номын сан дахь бүтээлийг ашиглах

4.1. Хэрэглэгч цахим номын сан дахь бүтээлийг ашгийн бус зорилгоор гагцхүү судалгаа, эрдэм шинжилгээний ажлын хэрэгцээнд ашиглана. Хэрэглэгч цахим номын сангаас уншсан, татаж авсан бүтээлийг өөрчлөн нийтлэх, нийтэд түгээх, хувиалан тараах, худалдан борлуулах, мөн энэхүү арга замаар өөрийн хувийн зорилгод ашиглахгүй байх үүрэгтэй.

4.2. Хэрэглэгч бүтээлийг судалгаа, эрдэм шинжилгээний зорилгоор ашиглахдаа ишлэл, зүүлт авах зэргээр эх сурвалжийг заан зохиогчийн эрхийг зөрчихгүйгээр, зүй ёсоор ашиглана.

Тав. Төлбөр тооцоо

5.1. Хэрэглэгч үйлчилгээний болон цахим бүтээл унших нэг удаагийн эрхийн төлбөрийг цахимаар төлнө.

5.2. Бүртгэлтэй хэрэглэгчид "Үнэгүй" төрөлд хамаарах бүтээлийг хязгааргүй хандаж үзэх эрхтэй.

5.3. Хэрэглэгч цахим номын санд байршсан "Үнэтэй " бүтээл бүрийг татаж авах бүрт ХЗҮХ-ээс тогтоосон төлбөрийг төлнө.

5.4. Хэрэглэгч бүтээлийг татах, уншихын өмнө бүтээлийн зохиогч, товч агуулга, хуудасны тоо зэрэг мэдээлэлтэй урьдчилан танилцаж сонголтоо хийх бөгөөд хэрэглэгчийн төлсөн төлбөрийг буцаан олгохгүй болно.

Зургаа. Хариуцлага

6.1. Хэрэглэгч энэхүү нөхцөлд заасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд ХЗҮХ өөрийн санаачилгаар тухайн хэрэглэгчийн нэвтрэх эрхийг хасч, хэрэглэгчийн бүртгэлийг хүчингүй болгон учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

6.2. Хэрэглэгч нь гуравдагч этгээд болон www.library.nli.mn цахим хуудсанд учруулсан хохирлыг зохих хууль тогтоомжийн дагуу барагдуулах үүрэгтэй.

Долоо. Гэрээний нөхцөл хүчин төгөлдөр болох

7.1. Хэрэглэгч цахим хуудсанд нэвтрэхдээ нөхцөлийн доорх "Би зөвшөөрч байна" гэсэн сонголтыг сонгосноор энэхүү нөхцөл хүчин төгөлдөр болно.